



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2023.01.10 № 2/119  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ  
ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА Т.ЭНХБАЯР ТАНАА**

Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд эрүүл мэндийн салбарын 2022 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан болон агентлаг, байгууллагад ажиллаж буй албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 12 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

*Ц.Эрдэмбилэг*

Ц.ЭРДЭМБИЛЭГ



145223036

## Хавсралт 1.

## Жендэрийн салбар зөвлөлийн гишүүдийн товч мэдээлэл

| № | Салбар зөвлөлийн гишүүний овог нэр | Хүйс | Байгууллага, албан тушаал/ Мэргэжил                  | Улсад ажилласан жил | Төрийн албанд ажилласан жил | "Жендэр ба бодлого төлөвлөлт" анхан шатны сургагч багшийн гэрчилгээ авсан эсэх | Төрийн албаны удирдах албан тушаалтны жендэрийн цахим сургалтад хамрагдсан эсэх | Утасны дугаар | Цахим хаяг            | Жендэрийн салбар зөвлөлийн чиг үүргийн хүрээнд хариуцаж буй үйл ажиллагааны чиглэл / |
|---|------------------------------------|------|--|---------------------|-----------------------------|--|---|---------------|-----------------------|--|
| 1 | Ц.Эрдэмбилэг                       | Эр   | ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга / эмч             | 20                  | 2                           | Үгүй   | Үгүй  | 99275757      | erdembileg@moh.gov.mn | Дарга  |
| 2 | Б.Уянга                            | Эм   | ЭМЯ-ны Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн / эмч | 14                  | 5                           | Тийм   | Үгүй  | 99196455      | uyanga@moh.gov.mn     | Нарийн бичгийн дарга   |

## Хавсралт 2.

## Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар салбарт баримтлах бодлогын Хэрэгжилт, үр дүнгийн талаарх хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн тайлан

| №   | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2021-12-31 | Зорилтот түвшин 2023-12-31 | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) | Салбар зөвлөлийн өөрийн үнэлгээ | ХШҮДАГ-ЫН үнэлгээ |
|---|---------------------------------------|-------|------------------|-------------------------|----------------------------|--|---------------------------------|-------------------|
| <p>Бодлогын баримт бичиг: Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 14-ний А/625 дугаар тушаалаар баталсан Эрүүл мэндийн салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого.</p> <p>Бодлогын зорилго: Эрүүл мэндийн салбарын бүх түвшинд ажиллагсдын жендэрийн боловсролыг дээшлүүлж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээ, нөхцөл байдлыг тооцсон, үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй жендэрийн мэдрэмжтэй бодлого, бүтэц, үйлчилгээний орчин бүрдүүлж, хөгжүүлэх</p> <p>Бодлогын зорилт 1: Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын жендэрийн мэдлэг, хандлага, чадавхийг дээшлүүлэн мэргэшүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх</p> |                                       |       |                  |                         |                            |  |                                 |                   |

|   |   |            |   |   |                               |  |  |  |
|---|---|------------|---|---|-------------------------------|--|--|--|
| 1.1.  | Эрүүл мэндийн чиглэлээр их, дээд сургууль, коллежид элсэгчдийн хүйсийн зохистой байдлыг хангахад чиглэсэн ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулах | -          | Ухуулга, нөлөөллийн ажил зохион байгуулах ажлыг эхлүүлэх,   | - | -                             | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулийн мэдээлэл авах, төгссөн болон элссэн оюутнуудын тоог хүйсээр авах тухай албан бичгийг БШУЯ-нд 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 6/4226 дугаар албан бичгийг хүргүүлж мэдээлэл авсан. Нийт 9 их дээд сургуульд сүүлийн 3 жилийн байдлаар 2660 эрэгтэй, 9733 эмэгтэй оюутан элсэж, 1852 эрэгтэй, 7102 эмэгтэй оюутан эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтнээр төгссөн байна. |  |  |
| 1.2.  | Эрүүл мэндийн салбарт Жендэрийн сургагч багш бэлтгэх  | 8.650.000  | Сургагч багшийн тоо   | 2 | 15                            | АХБ-ны "Халдварт бус өвчний хяналт, эмийн аюулгүй байдлыг сайжруулах төслийн санхүүгийн дэмжлэгээр "ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу 5-9 сард 5 удаагийн сургалтаар анхан шатны 5, 2-р зэргийн гэрчилгээтэй 13 сургагч багш бэлтгэсэн. Бүгд эмэгтэй байв.   |  |  |
| 1.3.  | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд жендэрийн асуудал хариуцсан мэргэшсэн хүний нөөцийг бий болгон ажиллуулах, чадваржуулах                             | -          | Салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зөвлөл, хороо, комиссын бүрэлдэхүүн, хүйсийн ангиллын мэдээлэл гаргах | - | 16                            | Эрүүл мэндийн салбарт тогтмол үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх нийт 16 хороо, зөвлөл, комисс ажиллаж байна. Нийт гишүүдийн тоо 207 гишүүдээс эрэгтэй удирдлага 59, эмэгтэй удирдлага 49, эрэгтэй гишүүд 34, эмэгтэй гишүүд 51 хүн бүрэлдэхүүнд байдаг.   |  |  |
| 1.4.  | Эрүүл мэндийн бүртгэл мэдээлэл, үзүүлэлтийг бүх шатанд хүйсээр ангилан салбарын статистикийг жендэрийн мэдрэмжтэй болгох                            | 70,175,000 | Эрүүл мэндийн үзүүлэлт, мэдээлэл, тусламж, үйлчилгээнд дүн шинжилгээ хийх   | - | Судалгааны ажил хийсэн байна. | НҮБХАС-ийн Жендэрт суурилсан хүчирхийлэл төслийн санхүүжилт, техникийн дэмжлэгээр жендэрт суурилсан хүчирхийллийн үед үзүүлэх Эрүүл мэндийн салбарын бэлэн байдлын үнэлгээг 3 аймаг, 6 дүүрэг, төрөлжсөн мэргэшлийн 3 эмнэлэг, анхан шатны   |  |  |
| Бодлогын зорилт 2: Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөв, нөөц хуваарилалт, шийдвэр гаргахад хүйсээр ангилсан бүртгэл, мэдээлэл, судалгаанд үндэслэдэг болгох |   |            |   |   |                               |  |  |  |

|      |   |             |   |   |  |  |  |  |
|------|---|-------------|---|---|--|--|--|--|
| 1.5. | Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, нас баралт, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг жендэрийн ялгаатайгаар үнэлж, үр дүнг бодлого, хөтөлбөр, төсвийн төлөвлөлтөд тусгах               |             | Эрүүл мэндийн статистик мэдээллийн үзүүлэт бүрийг хүйсээр ангилан тайлагнаж дүгнэдэг болгох | Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаал | Хүйсээр ангилан ялгаж тайлагнах                                    | <p>Эрүүл мэндийн статистик, бүртгэл, тайлангийн үй ажиллагаа нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу хүн амын эрүүл мэндийн байдлыг бүртгэж тайлагнадаг.</p> <p>Эрүүл мэндийн бүртгэлийн хүн амын өвчлөл, нас баралт, тусламж, үйлчилгээтэй холбоотой хувь хүнээр бүртгэгддэг маягтууд нь бүгд нас, хүйсээр ангилан гаргаж тайлагнах боломжтой.</p> <p>Эрүүл мэндийн салбар нь 1997 оноос эхлэн хүн амын өвчлөлийн мэдээллийг Өвчний олон улсын ангиллын дагуу бүртгэн, тайланг гаргаж байна.</p> <p>Албан ёсны статистикаар бүртгэгдэж, Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу тайланг “Эрүүл мэндийн статистик үзүүлэлт” цуврал ботийн 2,3,4-р нь хүн амын өвчлөл, нас баралтын дэлгэрэнгүйг гаргадаг бөгөөд олон нийтэд ил тод <a href="http://hdc.gov.mn">hdc.gov.mn</a> вэб сайтаар дамжуулан хүргэдэг.</p>  |  |  |
| 1.6. | Жендэрт суурилсан хүчирхийлэлд хохирогчдод эрүүл мэндийн тусламж үзүүлэгчдийн мэдлэг, ойлголт, чадварыг сайжруулах сургалтад бүх аймаг дүүрэг, сум өрхийн ЭМБ-ын эмч мэргэжилтнүүдийг хамруулах | 154,187,000 | Эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалт зохион байгуулах                           | 20 ЭМБ-ын 175 эмч эмнэлгийн мэргэжилтэн         | 20 ЭМБ-ын 60 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулсан байх | <p>НҮБХАС-ийн Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд чадавхжуулах, хохирогч болон үйлдэгчдэд сэтгэл заслын тусламж үзүүлэх арга техникийн сургалтыг 11 аймгийн нийт 483 / эрэгтэй 89, эмэгтэй 394/ эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан.</p> <p>Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлэгч БЗД, ЧД, СБД-ийн Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах талаар өдөрлөг зохион байгуулсан.</p> <p>Хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлдэг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээний төвд 2022 оны байдлаар 2022 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар 1097 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс том хүн-956 /эрэгтэй 96, эмэгтэй 860/, хүүхэд-141 /эрэгтэй 79, эмэгтэй 62/ тус тус үйлчлүүлсэн байна.</p> |  |  |
| 1.7. |   |             |   |   |  |  |  |  |

Боддлогын зорилт 3. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын эмч, эмнэлгийн ажиллагчдын ажиллах орчин болон иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг жөндөрийн мэдрэмжтэй болгох замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш боломж, чанар, хүртээмжийг сайжруулах

|      |   |             |  |     |     |   |  |  |
|------|---|-------------|--|-----|-----|---|--|--|
| 1.8. | Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, газар зүйн алслагдмал байдал, улирлын чанартай хөдөлмөр эрхлэлт зэрэг онцлог байдалд нийцсэн тусламж, үйлчилгээний зохистой хэлбэрийг хөгжүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийг санхүүжилтээр дэмжих | -           | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад тогтвор суурьшилтай ажилласан эмч нар урамшуулал олгож, төрийн зардлаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах | 10  | 30  | Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2022-2023 оны хичээлийн жилд сумын нэгдсэн эмнэлэг, сум тосгоны эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвөөс 8 чиглэлээр 14 эмч үүнээс улын төсвийн зардлаар 6, мэргэжил дээшлүүлэх сургалтад 11 чиглэлээр 58 эмч үүнээс улсын төсвийн зардлаар 25 эмч нийт 72 үүнээс улсын төсвийн зардлаар 31 эмч суралцсан.   |  |  |
| 1.9. | Эх хүүхэд нөхөн үржихүйн арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх   | 1,079,400,0 | Арга хэмжээний төлөвлөгөөний 2022 хэрэгжилтийг хангах  | 30% | 50% | Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр дүгнэж хяналт тавьж ажиллах талаар гурвалсан гэрээг 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Эрүүл мэндийн сайдын "Журам, гэрээний загвар, шалгуур үзүүлэлт батлах тухай" А/104 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.<br>Тус гэрээнд эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний хэрэгжилтэд үнэлгээ хийж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулсан.<br>Тусгай хэрэгцээ шаардлагатай жирэмсэн эмэгтэйд тусламж үзүүлэхээр ЭХЭМҮТ-ийн төрөх тасаг нэгдсэн дуудлагын систем, иж бүрэн тоноглолтой 14 төрөх өрөөтэй болсон.<br>Эхийн эндэгдлийн "Итгэмжит лавлагаа" судалгааны хүрээнд "Эх яагаад эндэв" 2016-2019 16 аймагт |  |  |

|  |   |  |   |  |   |   |  |  |
|--|---|--|---|--|---|---|--|--|
|  |   |  |   |  |   | <p>Бодлого боловсруулагч эмэгтэйчүүд, гэр бүлд зориулсан баримтын хуудсыг 720 ширхэгийг тараасан. "Коронавирусийн халдвар ба жирэмслэлт, төрөлтийн судалгаа"-аар корона вирусийн халдвар оношлогдсон 17,789 эхийн мэдээлэлд боловсруулалт хийн үр дүнг танилцуулсан.</p> <p>Улсын хэмжээнд 2022.10.31-ний байдлаар 53738 эх амаржиж, 54118 хүүхэд амьд төрсөн.</p> <p>Нийт 157 эх (жирэмсэн төрөх, төрсний дараах үед) амь насанд заналхийлсэн хүндрэлтэй байсны 18 тохиолдол эндэж, 139 эхийн амь нас аврагдсан.</p> <p>Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд) 33.3 просантимил, эхийн ноцтой хүндрэлийн харьцаа (1000 амьд төрөлтөд) 2.6 промил байна.</p> <p>Арга хэмжээний хэрэгжилт 2022 оны байдлаар 38.5% үнэлэгдсэн.</p>           |  |  |
| <p>Бодлогын зорилт 4. Эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээг харгалзсан эрүүл мэндийн жендэрийн мэдрэмжтэй мэдээлэл, сургалт, сурталчилгааг бусад салбарын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэх</p> |   |  |   |  |   |   |  |  |
| 1.10   | <p>Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээ, эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн эрүүл мэндийн мэргэшсэн үйлчилгээний төрлийг үндэсний хэмжээнд хөгжүүлж, хүний нөөцийг бэлтгэх</p> |  | <p>Төгсөлтийн дараах сургалтаар андрологийн төрөлжсөн мэргэшлийн эмчийг үе шаттайгаар бэлтгэх</p> |  | <p>Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмчийн тоо</p>        | <p>Бөөрний мэс засал судлалын төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2022-2023 оны хичээлийн жилд 18 үүнээс эрүүл мэндийн байгууллагын захиалгаар улсын төсвийн санхүүжилтээр 10 эмч суралцсан.</p> <p>Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, мэс засал судлал төрөлжсөн мэргэшлийн сургалтад 8, үүнээс эрүүл мэндийн байгууллагын захиалгаар улсын төсвийн санхүүжилтээр 2 эмч суралцсан.</p> <p>Бөөрний дурангийн мэс заслын багаж тоног төхөөрөмжөөр хангагдаж байгаа Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл 15 аймгийн бөөрний мэс заслын 16 эмч нарыг мэргэшил дээшлүүлэх сургалтад үүнээс улсын төсвийн зардлаар 15 эмч суралцсан.</p> |  |  |
| 1.11   | <p>Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, эрэгтэйчүүдийн кабинет /урологи,</p>   |  | <p>Урологи, андрологийн тусламж, үйлчилгээний бэлэн байдалд үнэлгээ хийсэн байна.</p>             |  | <p>Урологи, андрологийн чиглэлийн тусламж, үйлчилгээний бэлэн</p> | <p>Улсын хэмжээнд 2022 оны байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Урологийн эмч – 90</li> <li>- Андрологийн эмч- 15</li> <li>- Хүүхдийн урологийн эмч – 7 тус тус бэлтгэгдэн тусламж, үйлчилгээ үзүүлж байна.</li> </ul> <p>Аймгийн нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношилгоо, эмчилгээний төвд урологи, андрологийн чиглэлээр</p>   |  |  |

|  |  |  |  |   |   |  |  |
|--|--|--|--|---|---|--|--|
| <p>андрологи/<br/>тусламж,<br/>үйлчилгээг<br/>үзүүлдэг болсон<br/>байх</p> |  |  |  | <p>байдлын<br/>мэдээллий<br/>г нэгтгэсэн<br/>байна.</p> | <p>тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцөөр хангагдсан 20 аймагт 29 эмч ажиллаж байна.</p> <p>Урологи, андрологийн чиглэлээр сүүлийн 3 жилд 28 эмч бэлтгэгдсэн байна.</p> <p>2022 онд Улсын нэгдсэн төв эмнэлгийн Урологи-Андрологийн төвд 3 эмч урологи, 1 эмч андрологийн чиглэлээр суралцаж төгссөн.</p> <p>Аймгийн нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношилгоо, эмчилгээний төвд урологи, андрологийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцөөр хангагдсан 20 аймагт 29 эмч ажиллаж байна.</p> <p>Үүнд: (Архангай -1 эмч, Өвөрхангай -2 эмч, Хөвсгөл -3 эмч, Баянхонгор -2 эмч, Говь-Алтай -1 эмч, Ховд – 1 эмч, Увс -2 эмч, Баян-Өлгий -2 эмч, Завхан -2 эмч, Орхон -4 эмч, Дархан -2 эмч, Сэлэнгэ-1 эмч, Төв аймаг -1 эмч, Хэнтий -1 эмч, Дорнод -2 эмч, Сүхбаатар -1 эмч, Дорноговь -1 эмч, Өмнөговь -1 эмч, Говьсүмбэр -1 эмч, Дундговь -1 эмч)</p> <p>Үүнээс Хөвсгөл, Ховд, Увс, Дархан, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношилгоо, эмчилгээний төвд Андрологийн чиглэлээр мэргэшсэн нийт 5 эмч бэлтгэгдэн ажиллаж байна.</p> <p>2020-2022 онд Улсын нэгдсэн төв эмнэлгийн Урологи-Андрологийн төв, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн урологийн кабинет, Улсын гуравдугаар төв эмнэлгийн урологийн кабинет, АШУҮИС-ийн харьяа Монгол Японы эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Цэргийн төв эмнэлэгт нийт урологи, андрологийн тусламж, үйлчилгээг 11,244 үйлчлүүлэгчдэд үзүүлэн, эмчлэн эрүүлжүүлсэн байна.</p> <p>ЭХЭМҮТ-ийн Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн Үргүйдэл нөхөн үржихүйн төвд эрэгтэйчүүдийн үргүйдлийн оношилгоо, эмчилгээг нэвтрүүлснээр үр цацах эмчилгээний 60 үргүйдэлтэй эрэгтэйн төмсгөнд мэс засал хийж эр бэлгийн эсийг нь авч үргүйдлийн эмчилгээнд хэрэглэснээр 27 эмэгтэй жирэмсэлсэн байна.</p> <p>2022 онд аймгийн нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдэд давсганы хавдар</p> |  |  |
|--|--|--|--|---|---|--|--|

|   |  |  |   |     |     |  |  |  |
|---|--|--|---|-----|-----|--|--|--|
|   |  |  |   |     |     | болон чулууг дурангаар авах, шээлгүүрт стент тавих, шээсний сүвний нарийслыг эмчлэх дурангийн мэс засал эмчилгээ, бөөр авах, бөөрөнд нөхөн сэргээх мэс засал эмчилгээ хийх, шээсний сүвний уйланхай авах, варикэктоми, төмсөг буулгах, түрүү булчирхай авах мэс засал эмчилгээ болон түрүү булчирхайн эдийн шинжилгээ хийх зэрэг тусламж, үйлчилгээг шинээр нэвтрүүлэн нийт 135 үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээг орон нутагт үзүүлсэн байна. |  |  |
| 1.12  | Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээ батлан хэрэгжүүлэх |  | Арга хэмжээний төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилтийг хангах | 30% | 70% | Тус арга хэмжээний 2022 оны хэрэгжилт 35.8% үнэлэгдсэн   |  |  |
| Бодлогын 1 зорилго, 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээнд 233,012,000 төгрөг төсөвлөж. төсвийн зарцуулалт 100 хувь, үйл ажиллагааны хэрэгжилт 90 хувьтай байна. |  |  |   |     |     |  |  |  |



**Төрийн захиргааны төв, түүний харъяа агентлагт ажиллаж буй албан хаагчдын  
2022 оны хүйсийн тэнцвэрт байдлын жилийн мэдээ**

Тайлбар:Төрийн захиргааны төв байгууллага нь хавсралт 3-ын Маягт 1а, 1б, 1в, 1г, 1д, 1е-д заасан “яам”, “харъяа агентлаг” гэсэн мөрийг байгууллага тус бүрээр бөглөж, ЖҮХ-нд ирүүлнэ.

**Маягт 1а**

| № | Төрийн захиргааны төв болон түүний харъяа агентлагийн нэр | Төрийн албан хаагчид /үндсэн/ |        |     |
|---|---|-------------------------------|--------|-----|
|   |   | Нийт                          | Үүнээс |     |
|   |   |                               | эр     | эм  |
| 1 | Эрүүл мэндийн яам   | 83                            | 17     | 66  |
| 2 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар                     | 204                           | 45     | 159 |
| 3 | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар       | 110                           | 16     | 94  |

**Маягт 1б**

| № | Төрийн захиргааны төв байгууллагын нэр | Томилогдох төрийн улс төрийн албан хаагч |    | Үүнээс |    |          |    |       |    |
|---|--|--|----|--------|----|----------|----|-------|----|
|   |  |  |    | Сайд   |    | Дэд сайд |    | Бусад |    |
|   |  | эр                                       | эм | эр     | эм | эр       | эм | эр    | эм |
| 1 | Эрүүл мэндийн яам                      | 1  | -  | 1      | -  | -        | -  | -     | -  |

**Маягт 1в**

| № | Төрийн захиргааны төв байгууллагын нэр | Төрийн захиргааны албан хаагч |    | Үүнээс                      |    |                                |    |           |    |        |    |
|---|--|-------------------------------|----|-----------------------------|----|--------------------------------|----|-----------|----|--------|----|
|   |  |                               |    | Төрийн нарийн бичгийн дарга |    | Удирдах (газар хэлтсийн дарга) |    | Гүйцэтгэх |    | Туслах |    |
|   |  | эр                            | эм | эр                          | эм | эр                             | эм | эр        | эм | эр     | эм |
| 1 | Эрүүл мэндийн яам                      | 17                            | 66 | 1                           | -  | 3                              | 12 | 13        | 54 | -      | -  |

| № | Төрийн захиргааны төв байгууллагын харъяа агентлагийн нэр | Төрийн захиргааны албан хаагч |     | Үүнээс            |    |                                |    |           |     |        |    |
|---|---|-------------------------------|-----|-------------------|----|--------------------------------|----|-----------|-----|--------|----|
|   |   |                               |     | Агентлагийн дарга |    | Удирдах (хэлтэс, албаны дарга) |    | Гүйцэтгэх |     | Туслах |    |
|   |   | эр                            | эм  | эр                | эм | эр                             | эм | эр        | эм  | эр     | эм |
| 1 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар                     | 30                            | 141 | -                 | 1  | 8                              | 25 | 22        | 115 | -      | -  |

|   |  |    |    |   |   |   |   |    |    |   |   |
|---|--|----|----|---|---|---|---|----|----|---|---|
| 2 | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар | 13 | 65 | - | 1 | 1 | 3 | 12 | 61 | - | - |
|---|--|----|----|---|---|---|---|----|----|---|---|

**Маягт 1д**

| № | Төрийн захиргааны төв байгууллагын харъяа агентлагийн нэр | Төрийн үйлчилгээний албан хаагч |    | Үүнээс            |    |                                |    |           |    |        |    |
|---|---|---------------------------------|----|-------------------|----|--------------------------------|----|-----------|----|--------|----|
|   |   |                                 |    | Агентлагийн дарга |    | Удирдах (газар хэлтсийн дарга) |    | Гүйцэтгэх |    | Туслах |    |
|   |   |                                 |    | эр                | эм | эр                             | эм | эр        | эм | эр     | эм |
| 1 | Эрүүл мэндийн яам   | -                               | 7  | -                 | -  | -                              | -  | -         | 7  | -      | -  |
| 2 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар                     | 15                              | 18 | -                 | -  | -                              | -  | 15        | 18 | -      | -  |
| 3 | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар      | 3                               | 29 | -                 | -  | -                              | 1  | 3         | 28 | -      | -  |

**Маягт 1е**

| № | Хороо, зөвлөл, комиссын нэр  | Байгуулсан тушаал шийдвэр           | Нийт бүрэлдэхүүний тоо | Дарга/ахлагч |    | Гишүүд |    |
|---|--|-------------------------------------|------------------------|--------------|----|--------|----|
|   |  |                                     |                        | эр           | эм | эр     | эм |
| 1 | Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай     | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/150 | 23                     | 1            | -  | 10     | 12 |
| 2 | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл                                 | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/280 | 11                     | 1            | 1  | 5      | 4  |
| 3 | Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүн                                      | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/144 | 16                     | 1            | 1  | 8      | 8  |
| 4 | Төрийн албаны салбар зөвлөл  | ТАЗ-ийн 2021 оны 126 дугаар тогтоол | 7                      | 1            |    | 1      | 6  |
| 5 | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/619 | 9                      | 1            |    | 3      | 5  |
| 6 | Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөл                   | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/634 | 9                      | 1            |    | 1      | 7  |

|    |  |                                     |    |   |   |    |   |
|----|--|-------------------------------------|----|---|---|----|---|
| 7  | Цахим эрүүл мэндийн удирдах хорооны бүрэлдэхүүн  | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/196 | 12 | 1 |   | 6  | 5 |
| 8  | Гадаад улсад сайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах зөвлөл | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/370 | 11 |   | 1 | 8  | 2 |
| 9  | Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн   | Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/195 | 22 | 1 | - | 12 | 9 |
| 10 | Олон улсын эрүүл мэндийн дүрмийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн   | Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/195 | 18 |   | 1 | 8  | 9 |
| 11 | Вакцин, биобэлдмэлийн төлөвлөлт, зохицуулалтын хорооны бүрэлдэхүүн   | Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/195 | 11 |   | 1 | 3  | 7 |
| 12 | Халдварын сэргийлэлт, хяналтыг зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүн                              | Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/195 | 14 |   | 1 | 5  | 9 |
| 13 | Хиймийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах  | Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/195 | 16 |   | 1 | 8  | 7 |
| 14 | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн  | Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/195 | 10 |   | 1 | 3  | 6 |
| 15 | Хорт хавдраас сэргийлэх, зохицуулах удирдах хорооны бүрэлдэхүүн  | Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/195 | 11 |   | 1 | 5  | 5 |

**Тайлбар:**

- Төрийн захиргааны төв байгууллага нь: 1/ "Салбарын сайдын ахалсан үндэсний болон салбарын хэмжээний хороо, зөвлөл, комисс " , 2/Төрийн нарийн бичгийн даргын ахалсан хороо, зөвлөл, комисс", 3/ " Харьяа агентлагийн дарга нарын ахалсан хороо, зөвлөл, комисс " гэсэн мөрөн дэх мэдээллийг байгууллага тус бүрээр гаргаж, нэгтгэхгүйгээр тайлагнана.
- Төрийн захиргааны төв байгууллагын харъяа агентлаг нь: "Агентлагийн даргын ахалсан хороо, зөвлөл, комисс" гэсэн мөрөнд тухайн агентлагийн дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн мэдээллийг гаргаж, яаманд тайлагнана. Энэ мэдээнд орон нутаг дахь босоо удирдлагатай байгууллагуудын дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн судалгааг оруулахгүй.

**Жендэрийн тэгш байдлыг хангах талаар салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх  
Жендэрийн салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөө, төсөв**

| №  | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг   | Төсөв | Санхүүжилтийн эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин/ 2021-12-31 | Зорилтот түвшин/ 2023-12-31 | Хариуцах албан тушаалтан |
|--|---|-------|-------------------------|--|--------------------------|-----------------------------|--------------------------|
| <p><b>Бодлогын баримт бичгийн нэр, баталсан шийдвэрийн дугаар, огноо:</b> Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/625 дугаар тушаал, Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого.</p> <p><b>Бодлогын зорилго 1:</b> Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын жендэрийн мэдлэг, хандлага, чадавхийг дээшлүүлэн мэргэшүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх.</p>   |   |       |                         |  |                          |                             |                          |
| <p><b>Бодлогын зорилт 1,2:</b> Эрүүл мэндийн салбарын бүх түвшинд ажиллагсдын жендэрийн боловсролыг дээшлүүлж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээ, нөхцөл байдлыг тооцсон, үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй жендэрийн мэдрэмжтэй бодлого, бүтэц, үйлчилгээний орчин бүрдүүлж, хөгжүүлэх</p> <p><b>Үйл ажиллагааны чиглэл 1:</b> Эрүүл мэндийн салбарын жендэрийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрүүл идэвхтэй амьдралын мэдлэг, хандлага, дадлыг жендэрийн мэдрэмжтэй хэвшүүлэх чадавх бэхжүүлэх</p> <p><b>Үр дүн:</b> Эрэгтэй эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү багассан байна</p> |   |       |                         |  |                          |                             |                          |
| 1.1.   | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд жендэрийн асуудал хариуцсан мэргэшсэн хүний нөөцийг бий болгон ажиллуулж, чадваржуулах  |       | Улсын төсөв             | Чадавхжуулах сургалтад хамрагдсан ажилтан хүйсээр  | 0                        | 150                         | Б.Уянга                  |
| 1.2  | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний болон өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зардал, эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтад жендэрийн шинжилгээ хийж, шийдвэр гаргалтад ашиглана                         |       |                         | Эрүүл мэндийн нийт төсөвт нийгмийн эрүүл мэндийн тусламжид зарцуулсан хувь                             | 4                        | 6                           | Б.Уянга                  |
| 1.3  | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетыг стандартын дагуу аймаг, дүүрэг бүрт байгуулж, хүний нөөцийг бэлтгэж, тоног төхөөрөмжөөр хангана  |       |                         |  | 14                       | 20                          | Б.Уянга                  |
| 1.4  | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетаар үйлчлүүгчдийн тоог нэмэгдүүлэх нөлөөллийн стратеги хэрэгжүүлж байгаа Орхон зэрэг аймгийн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ |       |                         | Сайн туршлагыг нэвтрүүлэхэд Орхон аймгийн одоо байгаа хүчин чадал, үйл ажиллагааны тайлан, орон нутагт | 1                        | 5                           | Б.Уянга                  |

|     |  |  |  |  |     |     |         |
|-----|--|--|--|--|-----|-----|---------|
|     |  |  |  | сурталчлах<br>талаар албан<br>бичиг хүргүүлэх    |     |     |         |
| 1.5 | Аймгийн төвөөс алслагдмал амьдарч буй жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын явуулын тусламж, үйлчилгээг хөгжүүлж, эхийн амрах байртай болох нөхцөлийг бүрдүүлэх |  |  | Эхийн амрах байртай сумдын бичил судалгаа гаргах | 0 % | 10% | Б.Уянга |
| 1.6 | Жендэрийн эрх тэгш байдлын талаар ЭМБ-уудын удирдлагуудад цахим сургалт зохион байгуулах   |  |  | Сургалтад хамрагдсан удирдлагын тоо хүйсээр      | 0   | 100 | Б.Уянга |

Салбарын жендэрийн бодлогын 1 зорилго, 2 зорилтын хүрээнд 6 арга хэмжээнд ..... сая төгрөг төсөвлөв.

**Тайлбар:**

Холбогдох мэдээллийг Төсвийн санал бэлтгэх ЖМТ-НМ-02 маягаас авч болно.